

**СУДАЛГААНЫ НЭР:**

**БАГЦ ЦАГ БҮРДҮҮЛЭН  
МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА  
ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ СУНГУУЛСАН  
ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ БАГЦ  
ЦАГ БҮРДҮҮЛЭЛТЭД ХИЙСЭН  
ҮНЭЛГЭЭ**

**СУДЛААЧ:**

**Л.ОЮУНБИЛЭГ  
ХТХАА-ны МЭРГЭЖИЛТЭН  
Б.МӨНХЦЭЦЭГ  
ХТХАА-ны МЭРГЭЖИЛТЭН  
Л.МЯГМАРДОРЖ  
ЗСДХА-ны МЭРГЭЖИЛТЭН  
А.АЛТАНТУЛГА  
ЭЭЭШСҮАЗА-ны МЭРГЭЖИЛТЭН**

## **НЭГ. ҮНДЭСЛЭЛ**

Монгол улсад Эмнэлгийн тусlamж үйлчилгээг мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий эмнэлгийн мэргэжилтэн үзүүлнэ. Энэ нь Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйл, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалаар заасан журмаар зохицуулагдан олгогддог. Журамд:

- Хүний их, бага эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагч мэргэжлээр ажиллаж байгаа болон анагаах ухааны боловсрол олгох зөвшөөрөл бүхий гадаад, дотоодын их, дээд сургууль, коллеж төгсөж, дээрхи чиглэлээр ажиллах гэж буй эмнэлгийн мэргэжилтэн,
- Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл нь эмчлэх, эм барих, сувилах, эх барих, сэргээн засах гэсэн төрөлтэй байх,
- Уламжлалт анагаах ухаан, нүүр ам, хүний их эмч, эм зүйч нар жилд 6 багц цаг, сувилагч, эмнэлгийн бусад мэргэжилтэн жилд 3 багц цагийн сургалтад хамрагдана,
- Жил тутамд биелүүлэх багц цагийн 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж байгаа мэргэжлийн чиглэлээр, бусад нь ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр байна.
- Эмнэлгийн мэргэжилтэн тасралтгүй сургалт буюу багц цагийн богино хугацааны сургалтад хамрагдсанаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө сунгуулна гэж заасан.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлын 2020 оны 04 сарын 15-ны А/40 дугаар тушаалаар 2019 онд багц цаг бүрдүүлэн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан эмнэлгийн мэргэжилтний материалд хяналт үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн гишүүд 2020 оны 4 сарын 20-ны өдөр хуралдан “Эрүүл мэндийн хөгжлийн төв нь Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн ажлын албаны үйл ажиллагаанд дотоодын хяналтыг тогтмол хийж, үр дүнг тооцон шаардлагатай арга хэмжээг хэрэгжүүлнэ гэсэн заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Эмнэлгийн мэргэжилтний багц цаг бүрдүүлэлтэд үнэлгээ хийх ажлын удирдамж”-ыг боловсруулан Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирлаар батлуулан, ажил үүргийн хуваарийг гаргасан. Ажлын хэсгийн гишүүд 4 дүгээр сарын 25-наас 5 дугаар сарын 15-ны хооронд архивийн материалд дүн шинжилгээ хийж ажилласан.

## **ЗОРИЛГО**

Эрүүл мэндийн сайдын 2015 оны 98 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар батлагдсан журмын 8.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө сунгуулсан эмнэлгийн мэргэжилтний багц цаг бүрдүүлэлтэд хяналт үнэлгээ хийх

## **ЗОРИЛТ**

- 2015 онд батлагдсан “Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох” Эрүүл мэндийн сайдын тушаалтай танилцах
- Эрүүл мэндийн сайдын тушаалд орсон эмнэлгийн мэргэжилтний тооноос мэргэжлийн чиглэл бүрээр, төлөөлж чадахуйц түүврийн тоог тооцоолон гаргах

- 2019 онд багц цаг бүрдүүлэн мэргэжлийн үйл ажиллагаагаа сунгуулсан хүний их эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмчийн багц цаг бүрдүүлэлтэд хяналт үнэлгээ хийх
- 2019 онд багц цаг бүрдүүлэн мэргэжлийн үйл ажиллагаагаа сунгуулсан сувилагч, тусгай мэргэжилтний багц цаг бүрдүүлэлтэд хяналт үнэлгээ хийх

## **ХҮРЭХ ҮР ДҮН**

- 2019 онд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө сунгуулсан хүний их, бага эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагч мэргэжлээр ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтний багц цаг бүрдүүлэлтэд хяналт үнэлгээ хийгдсэн байна.
- Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн багц цаг бүрдүүлэлтийн материалд тавигдах шаардлага сайжирна.
- Үнэлгээний тайлан, зөвлөмж гарна.
- Эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журамд өөрчлөлт оруулахад нотолгоо мэдээлэл болно.

## **ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ, МАТЕРИАЛ**

### **ҮНЭЛГЭЭНИЙ АРГАЧЛАЛ**

Үнэлгээнд чанарын болон тоон судалгааны аргыг ашигласан.

### **МЭДЭЭЛЭЛ ЦУГЦЛУУЛАЛТ**

Баримтын аргаар мэдээлэл цуглуулсан бөгөөд төвийн захирлын баталсан удирдамжинд хавсаргасан үнэлгээний шалгуур үзүүлэлтийн хуудас ашиглан ажлын хэсгийн гишүүд шалгуур бүрээр үнэлэн, дүн шинжилгээ хийлээ.

### **ХАМРАХ ХҮРЭЭ**

- 2019 онд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө сунгуулсан хүний их, бага эмч, уламжлалт анагаахын их эмч, нүүр амны их эмч, эх баригч, эм зүйч, эм найруулагч, сувилагч мэргэжлээр ажиллаж буй эмнэлгийн мэргэжилтэн

## **ТҮҮВРИЙН ТОО**

- 2019 онд ЭМСайдын тушаалаар мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгуулсан нийт эмч эмнэлгийн мэргэжилтнийг эх олонлогоор авч, төлөөлж чадахуйц түүврийн тоог түүвэр олонлогоор сонгосон.
- Түүврийн тоог бодож гаргахдаа нийгмийн эрүүл мэндийн судалгаанд ашигладаг OpenEpi программд оруулж тооцоолон гаргасан бөгөөд энэхүү түүвэрлэлт нь 95%-ийн үнэн магадлалыг хангана.
- Нийт түүвэр дотроос эмчлэх, сувилах чиглэлээр их эмчийн 2 жил, 5 жил, уламжлалтын эмчийн 5 жил, нүүр амны эмчийн 5 жил, эх зүйч 5 жил, хүний бага эмч 5 жил, уламжлалт бага эмч 5 жил, эх баригч 5 жил, эм найруулагч 5 жил, сувилагч 5 жил, уламжлалт сувилагч 5 жил гэсэн 11 чиглэлээр тус бүрийн тоог гаргахдаа үнэн

магадлалыг хангахын тулд нийт тоонд эзлэж буй төрөл тус бүрийн хувийг тооцоолон түүнийгээ түүврийн эх олонлогт бодож гаргасан.

- Аргачлалын дагуу 2019 оны ЭМСайдын тушаал дагуу архивлагдсан боть тус бүрээс энгийн санамсаргүй аргаар эмч, эмнэлгийн мэргэжилтний материалыг сонгон үнэлгээнд хамруулсан.

**ЭМСайдын тушаалын дагуу эмнэлгийн мэргэжилтэний бүрдүүлсэн материалд үнэлгээ өгөх түүвэрлэлтийн тоо**

№	Чиглэл	Тушаалын дугаар											Нийт	Үүнээс хяналт үнэлгээнд
		49	122	186	214	276	341	383	429	464	532	533		
1	Хүний их эмч - 2 жилийн хугацаатай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	19	11	13	11	42	194	128	336	26	8	16	804	65
2	Хүний их эмч - 5 жилийн хугацаатай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	25	31	24	79	160	211	144	356	120	145	273	1568	147
3	Уламжлалтын их эмч - 5 жилийн хугацаатай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	5	2	1	5	18	36	31	34	14	14	32	192	16
4	Нүүр амны их эмч - 5 жилийн хугацаатай эмчлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	0	2	2	2	8	9	10	16	11	9	32	101	5
5	Эм зүйч - 5 жилийн хугацаатай эм барих үйл	2	3	3	14	27	48	26	30	15	10	20	198	16

	ажиллагаа эрхлэх зөвшөөрөл													
6	Хүний бага эмч - 5 жилийн хугацаатай эмчлэх ўйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	7	18	3	15	20	29	109	15	58	54	63	391	32
7	Уламжлалт анагаах ухааны бага эмч - 5 жилийн хугацаатай эмчлэх ўйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	3	0	0	1	2	10	29	4	8	5	3	65	5
8	Эх баригч - 5 жилийн хугацаатай эх барих ўйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	9	2	3	6	26	41	102	13	139	37	71	449	38
9	Эм найруулагч - 5 жилийн хугацаатай эх барих ўйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	6	7		6	29	48	57	17	14	27	6	217	16
10	Сувилагч - 5 жилийн хугацаатай сувилах ўйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	56	45	27	107	264	348	490	112	301	336	277	2363	201
11	Уламжлалт анагаах ухааны сувилагч - 5 жилийн хугацаатай сувилах ўйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл	1	1	0	6	11	13	27	8	16	10	12	105	11

12	Нийт	133	122	76	252	607	987	1153	941	722	655	805	6453	<b>544</b>
----	------	-----	-----	----	-----	-----	-----	------	-----	-----	-----	-----	------	------------

## МЭДЭЭ МЭДЭЭЛЛИЙГ БОЛОВСРУУЛАХ

Мэдээллийг Microsoft office Excel, SPSS-20.0 программ дээр дискриптив ба статистикийн энгийн шинжилгээний аргыг ашиглан үр дүнгийн шинжилгээ хийсэн.

### ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

2019 оны архив хэрэг хөтлөлтийн материалаас 747 эмнэлгийн мэргэжилтний багц цаг бүрдүүлсэн материалд үнэлгээ хийсэн бөгөөд ЭМСайдын тушаалаар хамгийн их мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгагдсан сувилагчаас- 251, хүний их эмчийн 5 жилээс-179, хүний их эмчийн 2 жилээс- 114 зэрэг чиглэл тус бүрээс сонгосон тоо хувийг Хүснэгт 1-т харуулав.

Үнэлгээнд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдийн 93.8 хувь нь ажилтай, 5.8 хувь нь ажилгүй, 0.4 хувь нь ажилтай эсэхээ тэмдэглээгүй байв. Ажил эрхэлж буй эмч мэргэжилтнүүдийн 29.9 хувь анхан шатлалд, 33.1 хувь нь хоёрдугаар шатлалд, 12.6 хувь нь гуравдугаар шатлалын эмнэлэгт ажилладаг байв.

**Хүснэгт 1. Үнэлгээ хийсэн эмнэлгийн мэргэжилтний тоо, хувь**

	Тоо	Эзлэх хувь
<b>Нийт үнэлгээ хийсэн материал</b>	747	
• Хүний их эмч - 2 жил	114	15.3
• Хүний их эмч - 5 жил	179	24.0
• Уламжлалтын их эмч - 5 жил	22	2.9
• Нүүр амны их эмч - 5 жил	13	1.7
• Эм зүйч - 5 жил	29	3.9
• Хүний бага эмч - 5 жил	48	6.4
• Уламжлалт анагаах ухааны бага эмч - 5 жил	3	.4
• Эх баригч - 5 жилийн	45	6.0
• Эм найруулагч - 5 жил	32	4.3
• Сувилагч - 5 жил	251	33.6
• Уламжлалт анагаах ухааны сувилагч - 5 жил	11	1.5
<b>Ажилтай эсэх</b>		
• Тийм	701	93.8
• Үгүй	43	5.8
• Тэмдэглээгүй	3	.4
<b>Нийт ажил эрхэлж буй оролцогчдоос</b>		
• Анхан шатлал	223	29.9
• Хоёрдогч шатлал	247	33.1
• Гуравдугаар шатлал	94	12.6


Нийт үнэлгээнд оролцогсодын багц цаг бүрдүүлэлтийн материал бүрэн ирүүлсэн 659 хүн буюу 88.2% , дутуу ирүүлсэн 86 буюу 11.5% байв (График 1).

### График 1. Материал бүрдүүлэлт тоогоор




ЭМСайдын 98 дугаар тушаалаар батлагдсан Эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, нөхөн олгох, хүчингүй болгох журамд зааснаар их эмч, нүүр амны их эмч, эм зүйч жил тутам 6 багц цаг, хүний бага эмч, эх баригч сувилагч, эм найруулагч жил тутам 3 багц цагийн багтаамж бүхий сургалтанд хамрагдана гэж заасны дагуу үнэлэхэд нийт оролцогсод 91 хувиас дээш биелүүлэх ёстой багц цагаа биелүүлсэн байна (График 2.).

График 2. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн жил тутам багц цаг биелүүлсэн хувь.



Мөн жил тутам биелүүлэх багц цагийн 2/3-оос доошгүй нь тухайн ажиллаж байгаа мэргэжлийн чиглэлээр, бусад нь ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр байна гэж журамд заасан байдаг. Уламжлалт анагаах ухааны бага эмч 100%, эм зүйч 93%, нар багц цагаа үндсэн мэргэшлээрээ биелүүлсэн бол эх баригч 58%, нүүр амны их эмч 46% нар үндсэн мэргэшлээр бус өөр чиглэлийн багц цагийн сургалтанд хамрагдсан байна (График 3.).

График 3. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн үндсэн мэргэшлээрээ багц цагаа биелүүлсэн хувь.




Жил тутам биелүүлэх ёстой багц цагаа биелүүлсэн сувилагч нарын дундах үндсэн мэргэшлээр багц цагаа биелүүлсэн хувь 35.60%, хүний их эмчийн 5 жилийн зөвшөөрөл сунгуулсан эмч нар 24.08% -ийг эзлэж байна. Эсрэгээрээ жил тутам биелүүлэх ёстой цагаа биелүүлээгүй хүний их эмч нарын 40.54% , сувилагч нарын 24.32% нь үндсэн мэргэшлээрээ багц цагаа биелүүлэх богино хугацааны сургалтанд сууж багц цагаа биелүүлсэн байна (Хүснэгт 2) .

#### Хүснэгт 2. Үндсэн мэргэшлээрээ жил тутам багц цаг биелүүлсэн эмнэлгийн мэргэжилтний хувь

№	Мэргэжлийн чиглэл	Жил тутам биелүүлэх ёстой багц цагаа биелүүлсэн эсэх	
		тийм	үгүй
1	Хүний их эмч - 2 жил	11.52%	13.51%
2	Хүний их эмч - 5 жил	24.08%	40.54%
3	Уламжлалтын их эмч - 5 жил	3.10%	2.70%
4	Нүүр амны их эмч - 5 жил	1.92%	0.00%
5	Эм зүйч - 5 жил	3.84%	8.11%
6	Хүний бага эмч - 5 жил	6.94%	2.70%
7	Уламжлалт анагаах ухааны бага эмч - 5 жил	0.44%	0.00%
8	Эх баригч - 5 жил	6.50%	2.70%
9	Эм найруулагч - 5 жил	4.58%	2.70%
10	Сувилагч - 5 жил	35.60%	24.32%
11	Уламжлалт анагаах ухааны сувилагч - 5 жил	1.48%	2.70%
<b>Нийт</b>		<b>100.00%</b>	<b>100.00%</b>

Нийт материал бүрдүүлсэн эмнэлгийн мэргэжилтнүүдийн дунд ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр багц цаг бүрдүүлсэн байдлыг авч үзэхэд уламжлалт анагаах ухааны бага эмч нар 100%, хүний их эмчийн 2 жилээр сунгуулж буй эмч нар 86.7%, сувилагч нар 79.2% бүрдүүлсэн байсан бол эм найруулагч, уламжлалтын их эмч нар ёс зүйн сургалтанд хамгийн бага буюу тус тус 53.3%, 63.6% нь бүрдүүлсэн байна (График 4.). Энэхүү дүнгээр нийт эмнэлгийн мэргэжилтнүүд бүгд 50-аас дээш хувь нь ёс зүй, харилцаа хандлага, нийгмийн эрүүл мэндийн чиглэлийн сургалтанд хамрагджээ.

**График 4. Эмнэлгийн мэргэжилтнүүдийн ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр багц цаг бүрдүүлсэн байдал (хувиар)**



Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгуулах хугацаандаа мэргэшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байдлыг авч үзвэл:

- Мэргэшүүлэх сургалтад хүний их эмчийн /2 жил/ 37.8%, хүний их эмчийн /5 жил/ 32%, уламжлалтын их эмчийн 27.2% нь хамрагдсан бол эм зүйч (6.9%) нар мэргэшүүлэх сургалтанд хамгийн бага хувь хамрагдсан байна ( График 5). Бага эмч, эх баригч нар нь дүн бүртгэл, статистикч нарын төрөлжсөн мэргэшлийн сургалтанд хамрагддаг, харин эм найруулагч нар цаашид мэргэшдэггүй тул энэхүү үзүүлэлтэд хамрагдаагүй болно.
- Мэргэжил дээшлүүлэх сургалтад уламжлалтын их эмч (40.9%), нүүр амны их эмч (38.4%), хүний их эмчийн 5 жилээр (24.7%) үнэлгээнд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүдэд өндөр хувьтай хамрагдсан бол уламжлалт анагаах ухааны сувилагч, уламжлалт анагаах ухааны бага эмч нар сургалтанд хамрагдалт хангалтгүй байна (График 6). Бид мэргэжил дээшлүүлэх сургалтанд мөн мэргэжлийн зэрэг хамгаалсан эмнэлгийн мэргэжилтнүүдийг хамруулсан болно.

График 5. Мэргэшүүлэх сургалтанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний хувь




График 6. Мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний хувь



Багц цагийн бүрдүүлэлтэд олон улсын сургалт, семинарт хамрагдсан эсэх шалгуурыг хавсаргасан гэрчилгээний хуулбарыг үндэслэн үнэлэхэд нийт үнэлгээнд оролцогдоос 9.5% нь олон улсын сургалт семинарт оролцсон байв.

### Хүснэгт 3. Олон улсын сургалт, семинарт хамрагдалт

№	Нийт оролцогод	Тоо	Хувь
1	Хамрагдсан	71	9.5%
2	Хамрагдаагүй	643	86.1%
3	Нийт	714	95.6%

Олон улсын сургалт семинарт хамрагдсан 9.5% эмнэлгийн мэргэжилтгүүдийг чиглэлээр авч үзвэл уламжлалт анагаахын их эмч (33.3%), бага эмч (27.2%) нар тэргүүлж, нүүр амны их эмч (23.8%), хүний их эмчийн 5 жилийн (20.2%) зөвшөөрөл сунгуулсан эмч нар удаалж байна.

### Хүснэгт 4. Олон улсын сургалт семинарт хамрагдсан эмнэлгийн мэргэжилтний эзлэх хувь

№	Мэргэжлийн чиглэл	Хамрагдсан	Хамрагдаагүй
1	Хүний их эмч - 2 жил	1.20%	98.80%

2	Хүний их эмч - 5 жил	20.22%	79.78%
3	Уламжлалтын их эмч - 5 жил	27.27%	72.73%
4	Нүүр амны их эмч - 5 жил	23.08%	76.92%
5	Эм зүйч - 5 жил	13.79%	86.21%
6	Хүний бага эмч - 5 жил	2.08%	97.92%
7	Уламжлалт анагаах ухааны бага эмч - 5 жил	33.33%	66.67%
8	Эх баригч - 5 жилийн	4.44%	95.56%
9	Эм найруулагч - 5 жил	0.00%	100.00%
10	Сувилагч - 5 жил	6.80%	93.20%
11	Уламжлалт анагаах ухааны сувилагч - 5 жил	0.00%	100.00%
12	<b>Нийт</b>	<b>9.94%</b>	<b>90.06%</b>

Багц цаг бүрдүүлэлтийн хэлбэрээр нь авч үзвэл зайн сургалтанд нийт оролцогсын 6%, илтгэл тавих болон судалгааны ажил бие даан болон багаар хийж гүйцэтгэсэн 2.1%, мэргэжлийн ном, гарын авлага боловсруулахад оролцсон 1.5%, шинэ бүтээл тэргүүн туршлага нэвтрүүлсэн 0.7%, төгсөлтийн дараах сургалтанд багшилсан 0.7% тус тус эзлэж байна.

#### Хүснэгт 5. Нийт үнэлгээнд оролцогсын багц цаг бүрдүүлэлтийн хэлбэр тоо, хувиар

№	Нийт үнэлгээнд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүд	Зайн сургалт		Илтгэл тавих, судалгааны ажил		Мэргэжлийн ном, гарын авлага		Шинэ бүтээл, тэргүүн туршлага		Төгсөлтийн дараах сургалтанд багшилсан	
		тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь
1	тийм	30	4%	16	2.1%	11	1.5%	5	0.7%	5	0.7%
2	үгүй	684	91.6%	698	93.4%	703	94.1%	709	94.9%	708	94.8%
3	нийт	714	95.6%	714	95.6%	714	95.6%	714	95.6%	713	95.4%

#### ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНИЙ ЯВЦАД ГАРСАН АЛДАА, ЗӨРЧЛҮҮД

Үнэлгээний явцад цаашид анхаарч ажиллах шаардлагатай дараах алдаа, зөвлүүд байна.  
Үүнд:

- Хугацаа сунгуулахад бүрдүүлэх материалын жагсаалтыг журамд заагаагүй тул эмнэлгийн мэргэжилтнүүдийн материалыг бүрэн, дутуу гэж үнэлэх үндэслэл байхгүй;
- 25-аас дээш жил ажилласан гэх боловч нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар байхгүй;
- Эмч, эмнэлгийн мэргэжилтэн өргөдлийн маягтыг бүрэн бөглөдөггүй тул тухайн мэргэжилтний талаарх мэдээллийг олж авахад бэрхшээлтэй;
- Нэг байгууллагад хэт олон чиглэлээр сургалтын эрх олгогдсон;
- Сургалт эрхлэх байгууллага нь нэг сэдвээр 2-3 жил дараалан нэг газарт сургалтаа зохион байгуулсан;
- 1 удаагийн сургалтаар 2-3 багц цагийн гэрчилгээ олгогдсон;

- Эмнэл зүйн бус сургалтад хэт өндөр багц цаг олгогдсон;
- Хуурамч гэрчилгээний хуулбар хавсаргасан;
- Олон улсын сургалтын гэрчилгээ;
  - /Хаана аль улсад, ямар байгууллагаас зохион байгуулагдсан нь тодорхойгүй/
- Хугацаа дууссан мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хуулбарыг архивийн материалд хавсаргаагүй байгаа нь лицензийн хүчинтэй хугацаа хэзээ дууссан, хүчинтэй хугацаан дах багц цагийг тооцох боломжгүй зэрэг.

## **ТАВ. ДУГНЭЛТ**

Үнэлгээг хийхдээ төлөөлж чадахуйц түүврийн тоог бодож гарган 544 материалд хяналт үнэлгээ хийхээр төлөвлөсөн байсан боловч багийн гишүүд нийт 747 эмнэлгийн мэргэжилтний материалыг 2019 оны архивын хадгаламжийн нэгжээс ЭМСайдын тушаал тус бүрийн дагуу, санамсаргүй түүвэрлэлтийн аргаар түүвэрлэн үнэлгээ өгсөн.

### **1. МАТЕРИАЛ БҮРДҮҮЛЭЛТ**

ЭМСайдын 98 дугаар тушаалаар батлагдсан журамд багц цагаар сунгуулж буй эмнэлгийн мэргэжилтний бүрдүүлэх ёстой материалын жагсаалт гэж тусгагдаагүй хэдий ч Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргах өргөдлийн маягт, багц цаг бүрдүүлэлтийн тайлангийн маягт, дипломын хуулбар, иргэний үнэмлэхний хуулбар, 25-аас дээш жил ажилласан бол нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, багц цагийн гэрчилгээний хуулбарыг хавсаргасан бол бүрэн материал ирүүлсэн гэж авч үзсэн.

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах хүсэлт гаргах өргөдлийн маягт дээр үндэслэж тухайн эмнэлгийн мэргэжилтний мэргэжлийн чиглэл, ажил эрхлэлт, ажлын газар, улсад ажилласан жил, мэргэжлээрээ ажилласан жилийг тэмдэглэж авсан бөгөөд үнэлгээнд хамрагдагсад бүрэн гүйцэд бөглөлгүй үлдээх, дутуу орхисон байх зэрэг тохиолдол илэрсэн. Мөн тайлангийн маягтд тэмдэглэсэн сургалт, семинарын гэрчилгээний хуулбар зарим тохиолдолд дутуу хавсаргасан байв.

Хувийн өргөдөл болон ажлын газрын тодорхойлолтыг журамд тусгаагүй тул бүрдүүлэх ёстой жагсаалтад оруулж тооцоогүй болно.

Нийт үнэлгээнд оролцогдын багц цаг бүрдүүлэлтийн материал бүрэн ирүүлсэн 659 хүн буюу 88.2% , дутуу ирүүлсэн 86 буюу 11.5% .

### **2. БАГЦ ЦАГ БҮРДҮҮЛЭЛТ**

Багц цаг бүрдүүлэлтийн тайлангийн маягтай гэрчилгээний хуулбарыг тулгаж үнэлсэн. Үнэлгээнд гэрчилгээний хуулбар дутуу, нэр давхардсан сургалтын гэрчилгээтэй оролцогдыг багц цагаа биелүүлээгүй гэж тооцсон. Мөн лицензын хуулбар байхгүй байсан тул жилийн эхэнд эсвэл төгсгөлд сунгуулснаас хамаарч багц цагийн тоо 1-1.5 кредит дутуу тэмдэглэгдсэн байсан. Нийт үнэлгээнд оролцогдын 91% нь биелүүлэх ёстой багц цагаа биелүүлсэн байна.

Уламжлалт анагаах ухааны бага эмч (100%), эм зүйч (93%) нар багц цагаа үндсэн мэргэшлээрээ биелүүлсэн бол эх баригч (58%), нүүр амны их эмч (46%) нар үндсэн мэргэшлээр бус өөр чиглэлийн богино хугацааны сургалтанд хамрагдсан байна. Жишээлбэл: 5 жилийн 4 жилд бусад мэргэжлийн багц цагийн сургалтанд хамрагдсан, УАУ эмч УАУТХЭ-д ажилладаг ч дотрын, хүүхдийн, гэмтлийн сургалтанд суусан, Гарьд манлай эрэгтэйчүүдийн эмнэлэгт эмч хэдий ч хүүхэд, мэдээгүйжүүлгийн кредит цуглуулсан, НАС-н их эмч 2015, 2018 онд үндсэн мэргэшлээр бус ёс зүй харьцаа

хандлага, нийгмийн эрүүл мэндээр багц цагаа бүрдүүлсэн, хүний их эмч сэтгэцийн эрүүл мэндийн сувилахуйн сургалтад хамрагдсан гэх мэт.

Суралцсан багц цаг нь мэдлэг мэргэжлээ дээшлүүлсэн эсэхийг тухайн эмнэлгийн мэргэжилтэн нь багц цаг бүрдүүлэлтийн хэлбэрүүдээс зөвхөн богино хугацааны сургалтанд суусан, тэрхүү сургалт нь жил тутам давтан зохион байгуулагдаж гэрчилгээ авсан эсэхээр үнэлсэн.

Эмнэлгийн мэргэжилтнүүдийн 50%-аас дээш нь ёс зүй, харилцаа хандлага, хууль эрх зүй, нийгмийн эрүүл мэндийн чиглэлээр сургалтад хамрагдсан бөгөөд үүний уламжлалт анагаах ухааны бага эмч нар (100%), хүний их эмчийн 2 жилээр сунгуулж буй эмч нар 86.7%, сувилагч нар (79.2%) бүрдүүлж оролцсон байсан бол эм найруулагч, уламжлалтын их эмч нар ёс зүйн сургалтанд хамгийн бага буюу тус тус (53.3%), (63.6%) нь багц цагаа бүрдүүлсэн байна.

### **3. МЭРГЭЖИЛ ДЭЭШЛҮҮЛСЭН БАЙДАЛ**

Эрүүл мэндийн тухай хуулийн 28.1.5-д “мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэх, 5 жил тутамд төгсөлтийн дараах сургалтад байгууллагын зардлаар хамрагдах”, 29.8-д “ сум, тосгоны эрүүл мэндийн төв, багийн эмчийн салбар, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх тусгай эмнэлэгт 5 ба түүнээс дээш жил ажиллаж байгаа эмнэлгийн мэргэжилтнийг мэргэжил дээшлүүлэх сургалтад 5 жил тутамд улсын зардлаар хамруулна” гэж заасан байдаг.

Мэргшүүлэх болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдсан байдлыг үнэлэхэд эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл сунгуулах хугацаандаа 2 жилийн зөвшөөрөлтэй хүний их эмчийн 37.8%, 5 жилийн зөвшөөрөлтэй хүний их эмчийн 32%, уламжлалтын их эмчийн 27.2% нь мэргшүүлэх сургалтанд хамрагдсан байсан. Хүний их эмчийн 2 жилээр сунгуулсан эмч нар өндөр хувьтай гарч байгаа нь Анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургуулийг төгсөгчид шууд резидентийн сургалтанд хамрагдаж буйтай холбоотой байна.

Мэргэжил дээшлүүлэх сургалтын хувьд уламжлалтын их эмчийн 40.9%, нүүр амны их эмчийн 38.4%, 5 жилийн зөвшөөрөлтэй хүний их эмчийн 24.7% үнэлгээнд хамрагдсан эмнэлгийн мэргэжилтнүүд дундаа арай өндөр хувьтай харагдаж байна. Энэ нь ажиллаж байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтнүүд мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдалт маш муу, байгууллага эмч, мэргэжилтнүүдийнхээ мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллахгүй байгааг илэрхийлж байна.

### **4. ЖУРАМД ЗААСАН БУСАД БАГЦ ЦАГИЙГ ТООЦОХ АРГАЧЛАЛ-д тусгасан чиглэлийг авч үзэхэд:**

- олон улсын сургалт семинарт хамрагдсан байдлыг үнэлэхдээ хилийн чанадад болон Монгол улсад зохиогдсон сургалт, семинарыг олгосон гэрчилгээний хуулбарыг үндэслэн тооцсон. Нийт олон улсын сургалт семинарт хамрагдсан 9.5% эмнэлгийн мэргэжилтнүүдийг чиглэлээр авч үзвэл уламжлалт анагаахын их эмч (33.3%), бага эмч (27.2%) нар тэргүүлж, нүүр амны их эмч (23.8%), хүний их эмчийн 5 жилийн (20.2%) зөвшөөрөл сунгуулсан эмч нар удаалж байна.
- зайн сургалтанд нийт оролцогсдын 6%,
- илтгэл тавих болон судалгааны ажил бие даан болон багаар хийж гүйцэтгэсэн 2.1%,
- мэргэжлийн ном, гарын авлага боловсруулахад оролцсон 1.5%,

- шинэ бүтээл тэргүүн туршлага нэвтрүүлсэн 0.7%, төгсөлтийн дараах сургалтанд багшилсан 0.7% тус тус эзлэж байна.

Үнэлгээний дүнгээр ихэвчлэн “эмчлэх” чиглэлээр зөвшөөрлөө сунгуулж буй гурав дахь шатлалд ажилладаг эмнэлгийн мэргэжилтнүүд багц цагийн сургалтаас бусад хэлбэрээр багц цаг бүрдүүлсэн. Энэ нь анхан шат болон нэгдсэн эмнэлгийн түвшинд эмч, мэргэжилтнүүд идэвх санаачлага муутай, өөрийн мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх тал дээр анхаарч ажиллахгүй байгаа нь харагдаж байна.

Зайн сургалтад хамрагдсан 6% оролцогод нь 2014 онд зохион байгуулагдсан зайн сургалтад хамрагдсан байсан бөгөөд 2014 оноос хойш зайн сургалт зохион байгуулагдаагүй байна.

Судалгааны ажил хийж гүйцэтгэн түүнийхээ үр дүнгээр оюуны өмчийн газраар пантент авсан эмнэлгийн мэргэжилтэн 1 байсан нь бага ч гэсэн сайшаалтай байна.

Төгсөлтийн дараах сургалтанд багшилсан 0.7% ихэвчлэн анагаах ухааны их дээд сургуульд багшилдаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн байсан ба лавлагaa шатны эмнэлгээс төгсөлтийн дараах сургалт удирддаг эмч, эмнэл зүйн сургагч багш нар материал бүрдүүлэлтэд сургалт удирдсан тухай нотолгоо баримт бүрдүүлдэггүй байна.

## 5. АРХИВИЙН ХАДГАЛАМЖИЙН НЭГЖ ҮҮСГЭСЭН БАЙДАЛ

Архивийн хөтлөх хэргийн нэрийн жагсаалттай архивийн баримтын нэр болон ботийн дугаар тохирч байсан. Эмнэлгийн мэргэжилтний баг цаг бүрдүүлсэн материал хэтэрхий олон байгаа нь сургалтын цахим сан үүсээгүйтэй холбоотой. Ойролцоогоор 10 орчим эмнэлгийн мэргэжилтний бүрдүүлсэн материал 1 боть архивийн нэгжийг үүсгэж байсан. Архивийн нэгж журмын дагуу хаягжилт, дотоод товъёог, ашиглалтын хуудас, баталгааны хуудас бүрэн хийгдсэн байсан. Цаашдаа дараах зөрчилд анхаарч ажиллах хэрэгтэй байна. Үүнд: архивийн нэгжийн хаягийг зөв, тодорхой бичих, товъёогтой архивийн нэгжийн доторх эмнэлгийн мэргэжилтний нэр зөрөх, зарим архивийн нэгжийг үдэлт задарч байсан зэрэг.

## ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

### ЭМЯ-НЫ ТҮВШИНД:

- Эрүүл мэндийн тухай хуульд заасны дагуу Эмнэлгийн мэргэжилний нэгдсэн бүртгэлийн санг бий болгох;
- Журамд багц цагаа сунгуулах бүрдүүлэх материалын жагсаалтыг тодорхой болгох;
- Журамд эрүүл мэндийн байгууллагын хариуцлагыг тодорхой болгох;

### ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН ТҮВШИНД:

- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн багц цаг бүрдүүлэлтэд тавих хяналтаа сайжруулах;
- Эмч, эмнэлгийн мэргэжилтний мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх /сургалтад хамрагдахад чөлөө олгох, судалгааны ажил хийх, ном, гарын авлага боловсруулахад дэмжлэг үзүүлэх/;
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдэд багц цаг бүрдүүлэх арга хэлбэрүүдийн талаар мэдээлэл түгээх, зааварчилгаа өгөх;
- Эрүүл мэндийн тухай хуулийн 28.1.5, 29.8 дах заалтуудыг биелүүлж ажиллах;
- Сургалт эрхлэх байгууллагаас зохион байгуулж байгаа сургалтад хяналт тавих;
- Тухайн орон нутагтаа жил бүр нэг байгууллагын ижил сургалтыг авахгүй байх;

- Байгууллагын зүгээс гадаадын эрүүл мэндийн байгууллага, эмнэлэгтэй хамтран ажиллах, эмч, эмнэлгийн мэргэжилтнийг гадаад улсад богино хугацааны сургалтад 5 жилд багадаа 1 удаа хамрагдах боломжийг бий болгох.

### **ЭРҮҮЛ МЭНДИЙН ХӨГЖЛИЙН ТӨВ, АЖЛЫН АЛБАНЫ ТҮВШИНД:**

- Эмнэлгийн мэргэжилтний багц цагийн сургалтын мэдээллийг бүрэн цахимжуулах; /Энэ нь шаардлагагүй материал бүрдүүлэлтийн тоо цөөрөх; хуурамч, хууль бус материал, гэрчилгээ хавсаргах үйл явц хязгаарлагдах; асуудал хариуцсан мэргэжилтний ачаалал буурч, механик ажил багасна; цаг хугацаа, хөрөнгө мөнгө хэмнэнэ/;
- Техникийн ажилтны орон тоо бий болгох;
- Эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн мэргэжилтнүүдэд журамд заасан багц цаг бүрдүүлэлтийн асуудлаар мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэн сургалт зохион байгуулах;
- Эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг мэргэжлийн чиглэлээр судалгаа хийх боломжийг олгох үүднээс хүн ам, эмнэлгийн тусlamж үйлчилгээний үзүүлэлтээс суурь судалгаанд ашиглах боломжтой дата мэдээллийг байгууллагын сайтад байршуулах; /Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn/
- Сургалт эрхлэх байгууллагад багц цагийн сургалтын эрхийг олгоходоо зөвхөн үйл ажиллагааны чиглэлийн дагуу зөвшөөрөл олгож байх;
- Эмнэл зүйн бус сургалтад олгох багц цаг 1 багц цагаас илүүгүй байх;
- Журамд заасан 12 цагийн лекц эсвэл 24 цагийн дадлага сургалт 1 багц цагтай тэнцүү байх заалтыг мөрдөх; /Энэ нь 1 өдрийн сургалт 0,5 багц цагтай байхаар дүйцэж байгаа юм/;
- Эх баригч, бага эмч, эм найруулагч нарт зориулсан сургалтанд түлхүү анхаарч ажиллах;
- Зорилтот бүлэгт чиглэсэн зайн сургалтыг 7 хоног бүр тогтсон хугацаанд тулгамдсан сэдвийн хүрээнд орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнд телемедицин ашиглан зохион байгуулах, сургалтыг тогтмолжуулах; /Энэ нь нэг дор олон аймгийн түвшинд тухайн сургалтын агуулгаар нэгдсэн нэг ойлголттой болох, хоорондоо мэдээллээ солилцох, туршлагаа хуваалцах, мэргэжлийн эмч, багшаас зөвлөгөө авах боломжийг бүрдүүлдэг/;
- Архивийн нэгжийг цахимжуулах, шаардлагагүй баримтыг архивын баримтад оруулахгүй байх;